

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар такси каб ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/29/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Ниямазон аудит ХХК, захирал 3.Цээнээ Утас: 99135906 Цахим хаяг: audit@nmz.mn Аудитын менежер: Ж.Батнасан Утас: 99077440 Цахим хаяг: batnasan@nmz.mn Аудитор: Т.Оюун Утас: 99006025 Цахим хаяг: oyuntl@yahoo.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 607
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ТАКСИ КАБ
ХХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ УЛААНБААТАР
ХОТЫН ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ДАШДЭМБЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар такси каб ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар такси каб ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 20,742.4 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд НББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчим алдагдсан байна. Тус байгууллага 2018 онд байгуулагдсанаасаа хойш компанийн дүрэмд заасан үйл ажиллагааг эрхлээгүй байна.

Аудитын гол асуудал

Компанийн нийт хөрөнгө 22,510.6 мянган төгрөг, нийт өр төлбөр 43,253.0 мянган төгрөг болж өөрийн хөрөнгөгүй болсон байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компани нь тайлант онд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй, биелэлтийн тайлангүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	38,787.96	26,787.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,153,000.00	4,153,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,191,787.96	4,179,787.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,277,350.81	18,330,850.81
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,277,350.81	18,330,850.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,469,138.77	22,510,638.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,153,000.00	6,153,000.00
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	-	37,100,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,153,000.00	43,253,000.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,153,000.00	43,253,000.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	100,000.00	100,000.00
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	29,990,000.00	29,990,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(9,773,861.23)	(50,832,361.23)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(3,815,361.23)	(41,058,500.00)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(5,958,500.00)	(9,773,861.23)
2.3.11	Эздийн өмчийн дүн	20,316,138.77	(20,742,361.23)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	26,469,138.77	22,510,638.77

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,958,500.00	5,958,500.00
12	Бусад зардал	-	35,100,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(5,958,500.00)	(41,058,500.00)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,958,500.00)	(41,058,500.00)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,958,500.00)	(41,058,500.00)
24	Орлогын нийт дүн	(5,958,500.00)	(41,058,500.00)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(3,766,149.19)	26,323,850.81
02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(49,212.04)	(49,212.04)
03	Залруулсан үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	(3,815,361.23)	26,274,638.77
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(5,958,500.00)	(5,958,500.00)
09	2022 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(9,773,861.23)	20,316,138.77
11	Залруулсан үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	(9,773,861.23)	20,316,138.77
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(41,058,500.00)	(41,058,500.00)
17	2023 оны 12 сарын 31	100,000.00	29,990,000.00	(50,832,361.23)	(20,742,361.23)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн зарлагын дүн	61,212.04	12,000.0
Бусад мөнгөн зарлага	61,212.04	12,000.0
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,212.04)	12,000.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(61,212.04)	12,000.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,000.00	38,787.96
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,787.96	26,787.96

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар компанийн өөрийн хөрөнгөтэй холбоотой зөрчил¹ илэрч 1 зөвлөмж өгсөн.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улаанбаатар такси каб ХХК-ийн хөрөнгөнөөс өр төлбөрийг хасч тооцоход сөрөг гарч / 22,510,638.77 - 43253000 = -20,742,361.23 / өөрийн хөрөнгөгүй болсон	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		